

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД
ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ “ГОВЬ-АЛТАЙ 80+” ХӨТӨЛБӨРИЙН 2024 ОНЫ ХЭРЭГЖИЛТЭД
ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2024.12.25

Алтай хот

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго, үндэслэл, арга зүй

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлж буй “ГОВЬ-АЛТАЙ 80+” хөтөлбөрийн 2024 оны хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж, үйл ажиллагааны гүйцэтгэлийг 2024 онд тавьсан зорилт, хүрэх түвшинтэй харьцуулан хэрэгжилтийн түвшинг тогтоох, үр дүнг үнэлэх, зөвлөмж, дүгнэлт гаргах, удирдлагыг үнэн зөв, бодит мэдээллээр хангах, дараагийн шатны төлөвлөсөн зорилтыг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

1.2 Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй

Хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 2021 оны 374 дүгээр тогтоолыг удирдлага болгож, бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн үнэлгээг тооцох аргачлалыг баримталлаа.

1.3 Ерөнхий мэдээлэл

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 61 дүгээр тогтоолоор “Говь-Алтай 80+” эрүүл мэндийн хөтөлбөрийг, аймгийн Засаг даргын 2024 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн А/553 дугаартай захирамжаар “Хөтөлбөр хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө 2024-2028” түүний хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинг тус тус баталсан байна.

2. “Говь-Алтай 80+” эрүүл мэндийн хөтөлбөрийн төлөвлөгөө нь 10 арга хэмжээ, 48 үйл ажиллагаатай, 40 үйл ажиллагаа суурь түвшингүй, 48 үйл ажиллагаа нь тодорхой шалгуур үзүүлэлттэй, 40 үйл ажиллагаа он оны хүрэх түвшинтэй, 8 үйл ажиллагаа ямар нэг хүрэх түвшингүй батлагдсан байна. Хөтөлбөрийн хэрэгжилтийг тайлагнахдаа 53 үйл ажиллагааны хэрэгжилт ирүүлсэнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж ажиллалаа.

ХОЁР. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН

2024 онд 53 арга хэмжээг хэрэгжүүлж 100 хувийн хэрэгжилттэй 33 арга хэмжээ, 90 хувийн хэрэгжилттэй 8 арга хэмжээ, 70 хувийн хэрэгжилттэй 1 арга хэмжээ, 30 хувийн

хэрэгжилттэй 5 арга хэмжээ, 0 хувийн хэрэгжилттэй 6 арга хэмжээ, нийт арга хэмжээний дундаж үнэлгээгээр 80.0 хувийн хэрэгжилттэй байна.

2. Эрчимжүүлэх шаардлагатай 11 арга хэмжээ байна. Үүнд”

№	Арга хэмжээний дугаар, агуулга	Хувь	Хариуцах хэлтэс, агентлаг
Эрчимжүүлэх шаардлагатай арга хэмжээнүүд			
1	1.3.1 Иргэдийн эрүүл мэндийн боловсролын түвшинг тодорхойлох судалгаа хийнэ.	30%	Эрүүл мэндийн төвүүд
2	2.1.5 Урьдчилан сэргийлэх үзлэгийн хамрагдалтыг нэмэгдүүлнэ.	30%	Эрүүл мэндийн газар
3	2.2.2 Нэгдсэн эмнэлгийн эрчимт эмчилгээний тасагт нэн шаардлагатай цусны хийн болон химийн анализатор аппарат нийлүүлнэ.	30%	Эрүүл мэндийн газар
4	2.4.14 Зам тээврийн ослоос урьдчилан сэргийлж А-0303 авто зам дагуу байрлалтай Дэлгэр сумын постод дундаж хурдны камер байрлуулна.	30%	Цагдаагийн газар
5	2.4.15 Зам тээврийн ослоос сэргийлж А-0303, А-0304 дугаартай авто зам дагуух 4 хар цэг дээр аюултай хэсгийн мэдээлэх самбар, тэмдэг байрлуулж камержуулна.	30%	Цагдаагийн газар
6	1.1.7 Сумын болон хамтарсан багийн үйл ажиллагаанд явцын үнэлгээ хийж, сайн туршлагыг түгээн сурталчилна.	0%	Эрүүл мэндийн газар
7	1.3.2 Үүрэн телефоны компаниудтай гэрээ байгуулж иргэдэд гар утсаар дамжуулан эрүүл мэндийн мэдээлэл хүргэнэ.	0%	Эрүүл мэндийн газар
8	2.1.6 Хөнгөвчлөх тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ.	0%	Эрүүл мэндийн газар
9	2.2.3 Нэгдсэн эмнэлгийн эрэгтэйчүүдийн кабинетийн тохижилтод дэмжлэг үзүүлнэ.	0%	Эрүүл мэндийн газар
10	2.3.6 Сумын эрүүл мэндийн төвийн эмнэлгээс шалтгаалах халдвараас сэргийлэх чиглэлээр сургалтад хамруулна.	0%	Эрүүл мэндийн газар
11	2.4.7 Байгууллагууд улирал бүр албан хаагчдын дунд нийтийн биеийн тамирын арга хэмжээ зохион байгуулж хэвшинэ.	0%	Биеийн тамир спортын газар болон бүх төрийн байгууллагууд,

ГУРАВ. ДҮГНЭЛТ

“Говь-Алтай 80+” эрүүл мэндийн хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ хийж дараах дүгнэлтийг гаргаж байна.

1. “Говь-Алтай 80+” эрүүл мэндийн хөтөлбөрийн хэрэгжилтийн 2024 оны хэрэгжилт 80.0 хувьтай байна.

2. “Говь-Алтай 80 +” эрүүл мэндийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө нь 40 үйл ажиллагаа суурь түвшингүй, 8 үйл ажиллагаа он оны хүрэх түвшингүй, 2024 оны хэрэгжилтийн тайлагнасан байдал төлөвлөгөөнөөс зөрүүтэй байгаа бөгөөд хөтөлбөр хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг шинэчлэн батлуулах шаардлагатай гэж дүгнэж байна.

ДӨРӨВ. ЦААШИД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ / ЗӨВЛӨМЖ /

1. “Говь-Алтай 80+” эрүүл мэндийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг шинэчлэн батлуулах;
2. “Говь-Алтай 80+” эрүүл мэндийн хөтөлбөрийн тухайн жилд хэрэгжүүлэх үйл ажиллагааг бүрэн хэрэгжүүлэх талаар арга хэмжээ авч ажиллах;

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС

